



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/117

Сүхбаатар сум

Буцалтгүй тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.1 г, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15.1, Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүхбаатар сумын 1 дүгээр багийн иргэн С.Нарантуяа нь ходоодны хүнд өвчний улмаас Улаанбаатаар хотын Хавдар судлалын үндэсний төвд оношилгоо шинжилгээнд зайлшгүй орох дүгнэлт, эрүүл мэндийн хүнд байдал, санхүүгийн хүнд нөхцөл, иргэний өргөдлийг үндэслэн үзэж, нэг удаагийн буцалтгүй тусламжийг хавсралтад зааснаар үзүүлсүгэй.


2. Буцалтгүй тусламжид шаардагдах 300000 /гурван зуун мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/ д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2020 оны 04 -р сарын 14 -ны
өдрийн А/117 дугаар захирамжийн
хавсралт



Сүхбаатар сумын 1 дүгээр багийн иргэн С.Нарантуяад
буцалтгүй тусламж үзүүлэх зардал

2020.04.09

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	Оношилгоо, шинжилгээний зардал	хүн	1	300000	300.000
НИЙТ ДҮН					300000

Төсөв гаргасан:

Б.Оюун
/АЗДТГ-ын НБХ-ийн ахлах мэргэжилтэн/

Төсөв хянасан:

З.Загдсүрэн
/АЗДТГ-ын нягтлан бодогч /